



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/04-НА-СТА-ТТЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Ерөө сум 2023 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор : Ц.Отгонбаяр Утас: 70362442 Цахим хаяг: Otgongbayarts@audit.gov.mn</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|-------------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АТӨЯХАТ | Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ОНХО | Орон нутгийн хөрөнгө оруулалт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ТБОНӨХБАҮХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТЗШ | Тусгай зориулалтын шилжүүлэг |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ХХААХҮЯ | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ХХС | Хоршоо хөгжүүлэх сан |



ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.СЭРГЭЛЭН ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023-03-25 № СЭА-2023/04-НА-СТА-ТТЗ

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс авлага үүсгэсэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, хөрөнгө борлуулсны орлогыг төрийн сангийн дансанд бус нярвын хувийн харилцах дансанд төвлөрүүлж, зарцуулалтын эрх үүсгэлгүйгээр зарцуулсан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж төсвийг арвилан хэмнэлтгүйгээр зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан зэрэг зөрчлүүд илэрлээ. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 35 дугаар зүйлийн 35.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 15.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Татварын ерөнхий хуулийн 28.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2.6, 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5, 2018 оны

134 дугаар тушаалын 3.2.1, 2019 оны 74 дүгээр тушаалын 1.4, 4.3, 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5, 3.1.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Ерөө сумын ТТЗ нь 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 86.7 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 13.3 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

ЕБС, цэцэрлэг болон эрүүл мэндийн байгууллагуудыг улсын төсвийн байгууллага болгосонтой холбоотойгоор ТТЗ-ийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|--------|---|-----------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 3,192,577.88 | 3,618,525.2 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 1,879,267.68 | 2,751,925.1 |
| 33 | АВЛАГА | 659,493.02 | 564,715.5 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 653,817.18 | 301,884.6 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 12,317,009.55 | 5,745,785.4 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12,317,009.55 | 5,745,785.4 |
| 39200 | Биет хөрөнгө | 11,887,881.34 | 5,498,757.6 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 429,128.21 | 247,027.8 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 15,509,587.42 | 9,364,310.6 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 259,703.58 | 123,395.2 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 259,703.58 | 123,395.2 |
| 41300 | Өглөг | 259,703.58 | 123,395.2 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 15,249,883.84 | 9,240,915.4 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 15,249,883.84 | 9,240,915.4 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 4,217,892.55 | 1,461,774.5 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 0.0 | 1,461,774.5 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 8,126,137.24 | 7,195,244.7 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,905,854.05 | 583,896.3 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 15,509,587.42 | 9,364,310.6 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|------|---------------------------------|-----------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 10,359,887.50 | 7,875,464.0 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 3,114,525.41 | 5,885,985.9 |
| 110 | Орлогын албан татвар | 113,426.89 | 2,298,478.2 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 113,426.89 | 2,298,478.2 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 115,829.57 | 156,820.6 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 2,885,268.95 | 3,430,687.1 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,213,387.72 | 893,188.3 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,043,387.72 | 893,188.3 |
| 122 | Тусламжийн орлого | 170,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,031,974.36 | 1,096,289.8 |

| | | | |
|------------|--|---------------------|---------------------|
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 6,561,795.52 | 5,173,437.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,561,795.52 | 4,782,321.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 6,321,925.58 | 3,348,232.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,163,328.01 | 702,099.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 403,813.40 | 90,241.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 834,379.10 | 1,263,059.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 458,574.68 | 167,983.8 |
| 2105 | Нормативт зардал | 445,647.85 | 55.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 115,342.12 | 57,890.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,641.63 | 7,107.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 123,595.45 | 40,759.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 774,603.33 | 1,019,034.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 239,869.94 | 1,434,089.4 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 391,116.4 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 3,798,091.98 | 2,702,026.2 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,209,814.90 | 8,707,064.5 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 2,588,277.08 | -6,005,038.3 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|-----------|---|--|-----------------------|------------------------|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 12,661,606.8 | 0.0 | 12,661,606.8 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 352.1 | 0.0 | 352.1 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 12,661,958.9 | 0.0 | 12,661,958.9 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -352.1 | 0.0 | -352.1 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 2,588,277.1 | 0.0 | 2,588,277.1 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 15,249,883.8 | 0.0 | 15,249,883.8 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 15,249,883.8 | 0.0 | 15,249,883.8 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -985,252.2 | 0.0 | -985,252.2 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 14,264,631.6 | 0.0 | 14,264,631.6 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | -6,005,038.3 | 0.0 | -6,005,038.3 |
| 20 | 2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 9,240,915.4 | 0.0 | 9,240,915.4 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|-------------|---|-----------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 8,621,053.15 | 7,447,255.80 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 3,114,525.41 | 5,885,985.90 |
| 110 | Орлогын албан татвар | 113,426.89 | 2,298,478.20 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 113,426.89 | 2,298,478.20 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 115,829.57 | 156,820.60 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 2,885,268.95 | 3,430,687.10 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 176,832.99 | 121,642.90 |
| 1181 | Газрын төлбөр | 96,146.35 | 457,088.20 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 2,612,289.61 | 2,851,956.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 580,230.68 | 464,980.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 410,230.68 | 464,980.10 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 170,000.00 | 1,096,289.80 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,926,297.06 | 4,369,803.70 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,959,002.78 | 4,369,803.70 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,959,002.78 | 2,912,255.40 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 5,723,090.55 | 708,151.40 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,108,142.24 | 92,031.90 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 404,565.91 | 1,263,059.70 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 817,228.10 | 173,119.30 |
| 2105 | Нормативт зардал | 229,392.45 | 18,952.20 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 555,265.50 | 58,654.30 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 142,801.59 | 7,107.80 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,641.63 | 32,705.60 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 147,903.36 | 558,473.20 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 315,149.76 | 1,457,548.30 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 235,912.24 | 3,077,452.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 2,662,050.36 | 2,204,794.60 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,190,719.01 | 2,204,794.60 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,190,719.01 | 2,204,794.60 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | 2,190,719.01 | -2,204,794.60 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -2,190,719.01 | 0.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | -265,500.00 | 0.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 265,500.00 | 872,657.40 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 205,831.35 | 1,879,267.70 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,673,436.32 | 2,751,925.10 |

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------|--|---------------------|---------------------|-------------------|---------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,529,267.20 | 4,791,946.50 | 737,320.70 | 86.67 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,010,076.90 | 2,844,045.50 | 166,031.40 | 94.48 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,973,781.80 | 2,808,434.00 | 165,347.80 | 94.44 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 755,552.90 | 701,646.60 | 53,906.30 | 92.87 |
| 210101 | Үндсэн цалин | 324,858.30 | 340,780.50 | -15,922.20 | 104.90 |
| 210102 | Нэмэгдэл | 80,224.50 | 73,908.50 | 6,316.00 | 92.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 27,342.00 | 21,452.60 | 5,889.40 | 78.46 |
| 210104 | Урамшуулал | 164,011.80 | 143,801.20 | 20,210.60 | 87.68 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 159,116.30 | 121,703.60 | 37,412.70 | 76.49 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 94,398.00 | 90,241.40 | 4,156.60 | 95.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,192.90 | 61,970.10 | 2,222.80 | 96.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,554.60 | 7,168.90 | 385.70 | 94.89 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,956.40 | 5,731.80 | 224.60 | 96.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,504.70 | 1,380.10 | 124.60 | 91.72 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,189.40 | 13,990.30 | 1,199.10 | 92.11 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,301,192.70 | 1,263,059.70 | 38,133.00 | 97.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 119,126.50 | 111,704.00 | 7,422.50 | 93.77 |
| 210302 | Түлш, халаалт | 1,111,099.90 | 1,083,800.80 | 27,299.10 | 97.54 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 70,366.30 | 67,554.80 | 2,811.50 | 96.00 |
| 210304 | Байрны түрээс | 600 | 0 | 600.00 | 0.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 171,772.00 | 169,618.60 | 2,153.40 | 98.75 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,457.40 | 12,074.10 | -616.70 | 105.38 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 70,361.40 | 70,477.50 | -116.10 | 100.17 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,135.50 | 7,633.30 | 1,502.20 | 83.56 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 65,000.00 | 65,000.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,818.10 | 14,433.60 | 1,384.50 | 91.25 |
| 2105 | Нормативт зардал | 639.4 | 639.4 | 0.00 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 639.4 | 639.4 | 0.00 | 100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 90,690.60 | 86,726.80 | 3,963.80 | 95.63 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 36,410.00 | 36,297.60 | 112.40 | 99.69 |
| 210602 | Тавилга | 5,000.00 | 5,000.00 | 0.00 | 100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 125 | 125 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 49,155.60 | 45,304.20 | 3,851.40 | 92.16 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,195.60 | 7,107.80 | 1,087.80 | 86.73 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,195.60 | 7,107.80 | 1,087.80 | 86.73 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 73,597.20 | 51,983.30 | 21,613.90 | 70.63 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 66,771.40 | 47,934.20 | 18,837.20 | 71.79 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 237.8 | 0 | 237.80 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,315.20 | 451.7 | 863.50 | 34.34 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,678.60 | 3,275.30 | 403.30 | 89.04 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 857 | 187 | 670.00 | 21.82 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 702.2 | 100 | 602.20 | 14.24 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 35 | 35 | 0.00 | 100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 477,743.00 | 437,410.10 | 40,332.90 | 91.56 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 471,101.90 | 430,769.00 | 40,332.90 | 91.44 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,641.10 | 6,641.10 | 0.00 | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36,295.10 | 35,611.50 | 683.60 | 98.12 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 36,295.10 | 35,611.50 | 683.60 | 98.12 |

| | | | | | |
|------------|---|---------------------|---------------------|-------------------|---------------|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 30,721.50 | 30,721.50 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,573.60 | 4,890.00 | 683.60 | 87.74 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,420,190.30 | 1,947,900.90 | 472,289.40 | 80.49 |
| 220001 | Барилга байгууламж | 1,576,079.90 | 1,160,437.80 | 415,642.10 | 73.63 |
| 221001 | Их засвар | 648,099.00 | 597,074.70 | 51,024.30 | 92.13 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 131,011.40 | 125,388.40 | 5,623.00 | 95.71 |
| 223001 | Бусад хөрөнгө | 65,000.00 | 65,000.00 | 0.00 | 100.00 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 99,000.00 | 0 | 99,000.00 | 0.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 99,000.00 | 0 | 99,000.00 | 0.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5,529,267.20 | 5,242,240.70 | 287,026.50 | 94.81 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0 | 0 | 0.00 | |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 0 | 0 | 0.00 | |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 5,339,565.20 | 4,875,047.90 | 464,517.30 | 91.30 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 4,567,834.90 | 4,103,317.60 | 464,517.30 | 89.83 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 771,730.30 | 771,730.30 | 0.00 | 100.00 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 189,702.00 | 367,192.80 | 177,490.80 | 193.56 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 141,885.00 | 367,192.80 | 225,307.80 | 258.80 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 47,817.00 | 0 | 47,817.00 | 0.00 |
| 350004 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 0 | 0 | 0.00 | |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|-------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 376,059.30 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 186,218.30 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 180,265.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 6,504.70 |
| 210101 | Үндсэн цалин | 6,504.70 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,790.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,790.40 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,500.60 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,500.60 |
| 2105 | Нормативт зардал | 18,312.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 18,312.80 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,251.80 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,251.80 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,290.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,290.60 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 145,614.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 145,614.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,953.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5,953.00 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 5,953.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 189,840.90 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 189,840.90 |
| 220001 | Барилга байгууламж | 139,840.90 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 50,000.00 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 349,451.30 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 349,451.30 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,648.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 250,850.10 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 77,953.10 |

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ерөө сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “*Иргэн таны оролцоотой эх нутгаа хөгжүүлбэ*” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*

- *Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,*
- *Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ. Тайлант онд дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ерөө сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан *“Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөөт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”*-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ерөө сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан *“Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”*-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,145,276.8 мянган төгрөгөөр буюу 39.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|----------------------|---------------------|-----------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,879,267.68 | 2,751,925.10 | 872,657.42 |
| Авлага | 659,493.02 | 564,715.50 | (94,777.52) |
| Бараа материал | 653,817.18 | 301,884.60 | (351,932.58) |
| Үндсэн хөрөнгө | 12,317,009.55 | 5,745,785.40 | (6,571,224.15) |
| Нийт хөрөнгө | 15,509,587.43 | 9,364,310.60 | (6,145,276.83) |
| Өр төлбөр | 259,703.60 | 123,395.20 | (136,308.40) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 15,249,883.84 | 9,240,915.40 | (6,008,968.44) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 15,509,587.44 | 9,364,310.60 | (6,145,276.84) |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байгаа бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,751,925.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 872,657.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-------------------------------|---------------------|---------------------|---------------------------|
| Банканд байгаа бэлэн мөнгө | 1,879,267.68 | 2,751,925.07 | 872,657.39 |
| Төрийн сангийн харилцах | 1,852,659.68 | 2,751,925.07 | 899,265.39 |
| Нэмэлт санхүүжилтийн харилцах | 26,608.00 | - | (26,608.00) |
| Дүн | 1,879,267.68 | 2,751,925.07 | 872,657.39 |

Эх сурвалж: Ерөө сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлагнагдсан Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 2,311,483.1 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 245,253.8 мянган төгрөг, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн үлдэгдэл 98,869.5 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 96,318.6 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 564,715.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 94,777.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------------------|-------------------|-------------------|------------------------|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 4,028.53 | | (4,028.53) |
| Зээлийн хүүгийн авлага | 28,005.33 | 29,054.30 | 1,048.97 |
| Байгууллагаас авах авлага | 127,448.33 | 113,835.30 | (13,613.03) |
| Хувь хүмүүсээс авах авлага | 32,621.20 | 32,621.30 | 0.10 |
| Хувь хүмүүст олгосон зээл | 467,389.63 | 389,204.60 | (78,185.03) |
| Дүн | 659,493.02 | 564,715.50 | (94,777.52) |

Эх сурвалж: Ерөө сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд ЗДТГ-ын 90,877.1 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 26,518.9 мянган төгрөг, Орон нутгийн ерөнхий орлогын 8,240.0 мянган төгрөгийн авлагууд бүртгэлтэй байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 77.7 хувь буюу 439,079.4 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ нь төлбөр тооцоог хянаагүйгээс ХХОАТ-ын 967.1 мянган төгрөгийн авлага үүсгэж, дутуу тайлагнасан,
- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Бугант тосгоны 2 км хайрган хучилттай зам барих ажил”-ын гүйцэтгэгч “Сэлэнгэ есөн эрдэнэ” ХХК-д 518.9 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү олгож авлага үүсгэсэн,
- ЗДТГ нь сумын хөрөнгө оруулалтын зардлаар санхүүжүүлсэн 97,526.0 мянган төгрөгийн гэрээтэй “Засаг даргын Тамгын газрын байрны зураг төсөв”-ийн ажлын урьдчилгаа 78,020.8 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй, санхүүгийн тайланд үнэн зөв, бодитой тайлагнаагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 301,884.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 351,932.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Тусгай зориулалттай материал | 79,770.13 | 6,694.60 | (73,075.53) |
| Эм боох материал | 17,959.64 | - | (17,959.64) |
| Бичиг хэргийн материал | 181.70 | 746.20 | 564.50 |
| Аж ахуйн материал | 216,548.10 | 68,776.50 | (147,771.60) |
| Сэлбэг хэрэгсэл | 1,120.00 | 250.00 | (870.00) |
| Түлш, шатах тослох материал | 102.20 | 1,990.60 | 1,888.40 |

СЭА-2023/04-НА-СТА-ТТЗ

| | | | |
|----------------------------|-------------------|-------------------|---------------------|
| Барилгын засварын материал | 121,002.20 | 111,710.40 | (9,291.80) |
| Хүнсний материал | 17,643.00 | - | (17,643.00) |
| Бусад хангамжийн материал | 185,290.21 | 77,516.30 | (107,773.91) |
| Мал амьтад | 14,200.00 | 34,200.00 | 20,000.00 |
| Дүн | 653,817.18 | 301,884.60 | (351,932.58) |

Эх сурвалж: Ерөө сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 351,932.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 177,625.6 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 996,921.5 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авсан, 44,485.2 мянган төгрөгийн хандив тусламж хүлээн авсан зэргээр нийт 1,219,032.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 191,154.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, орон нутгийн хөрөнгөөр хийгдсэн 996,921.5 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвүүд тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчид харьяалагдах болж, 382,889.3 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ нь 41,979.5 мянган төгрөг, Ойн анги нь 39,974.7 мянган төгрөг, Захирагчийн алба нь 35,027.8 мянган төгрөг, ИТХ нь 14,972.7 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй болон бөөн дүнгээр шивсэн,
- Ойн ангийн 7,777.2 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдлийг нэр, төрлөөр бус бөөн дүнгээр бүртгэсэн,
- ЗДТГ нь тайлант онд худалдан авсан 4,180.3 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, хүнсний материал, барилгын засварын материалыг бүртгэхдээ ангиллын дагуу бус бусад хангамжийн материалд бүртгэн тайлагнасан,
- Бугант тосгоны Захирагчийн алба нь тайлант онд худалдан авсан 927.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардлаар тайлагнасан байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 5,745,785.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,571,224.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------------|----------------------|---------------------|------------------------|
| Биет хөрөнгө | 11,887,881.35 | 5,498,757.60 | (6,389,123.75) |
| Барилга, байгууламж, орон сууц | 8,025,411.40 | 2,647,075.90 | (5,378,335.50) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 740,602.10 | 585,481.60 | (155,120.50) |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 835,863.05 | 228,626.50 | (607,236.55) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 265,104.70 | 58,455.50 | (206,649.20) |
| Зам гүүрийн байгууламж | 771,645.90 | 853,757.60 | 82,111.70 |

| | | | |
|-------------------------|----------------------|---------------------|-----------------------|
| Дуусаагүй барилга | 53,843.30 | - | (53,843.30) |
| Номын фонд | 106,749.30 | - | (106,749.30) |
| Бусад үндсэн хөрөнгө | 1,088,661.60 | 1,125,360.50 | 36,698.90 |
| Биет бус хөрөнгө | 429,128.20 | 247,027.80 | (182,100.40) |
| Программ хангамж | 11,806.80 | 2,740.00 | (9,066.80) |
| Бусад биет бус хөрөнгө | 417,321.40 | 244,287.80 | (173,033.60) |
| Дүн | 12,317,009.55 | 5,745,785.40 | (6,571,224.15) |

Эх сурвалж: Ерөө сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос /анхны өртгөөр/ 7,697,385.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 436,902.5 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 461,311.7 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан зэрэг 833,217.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 8,595,600.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр холбогдох ерөнхийлөн захирагчдад шилжүүлснээс голлон шалтгаалсан байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 123,395.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 136,308.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------------|-------------------|-------------------|------------------------|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 42,793.80 | | (42,793.80) |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 81,200.60 | | (81,200.60) |
| Байгууллагад төлөх өглөг | 125,291.60 | 123,395.20 | (1,896.40) |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 10,417.60 | | (10,417.60) |
| Дүн | 259,703.60 | 123,395.20 | (136,308.40) |

Эх сурвалж: Ерөө сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд өмнөх оны орон нутгийн хөгжлийн сангийн өглөг 4,205.8 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн дансны өглөг 98,869.5 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн өглөгийн үлдэгдэл 3,219.9 мянган төгрөг, Ойн ангийн 17,100.0 мянган төгрөгийн өглөг тайлагнагдсан байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 9,240,915.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,008,968.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---------------------|---------------------|------------------------|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,217,892.50 | 1,461,774.50 | (2,756,118.00) |
| Хуримтлагдсан үр дүн | 8,126,137.30 | 7,195,244.60 | (930,892.70) |
| Өмнөх үеийн үр дүн | 5,537,860.20 | 13,200,282.90 | 7,662,422.70 |
| Тайлант үеийн үр дүн | 2,588,277.10 | (6,005,038.30) | (8,593,315.40) |

| | | | |
|----------------------------------|----------------------|---------------------|-----------------------|
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,905,854.04 | 583,896.30 | (2,321,957.74) |
| Дүн | 15,249,883.84 | 9,240,915.40 | (6,008,968.44) |

Эх сурвалж: Ерөө сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,008,968.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **192,276.0** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

- ЗДТГ болон ТЗШ-ийн байгууллагын тогтмол зардлаас байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 70,000.0 мянган төгрөгийн зохицуулалт хийж, зарцуулсан бөгөөд гүйцэтгэлийн тайлан гаргаагүй,
- Тендерийн хэмнэлтээр сумын ОНХО-аар хэрэгжсэн 289,098.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгоны орон сууцуудын подвалын цэвэр, дулааны шугам шинэчлэх” ажилд 8,506.6 мянган төгрөгийн, ОНХС-аар хэрэгжсэн 274,786.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгоны 2 км хайрган хучилттай зам барих” ажилд 15,132.2 мянган төгрөгийн нэмэлт гэрээ тус тус байгуулсан,
- Сумын Засаг даргын 2022 оны А/273 дугаар захирамжаар ЗДНХ-өөс улсын төсөвт байгууллагуудын 7 албан хаагчдад 700.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон,
- Засаг даргын нөөц сангаас “Гамшгийн иж бүрэн сургалт” зохион байгуулахад 23,814.6 мянган төгрөг *Лүнээс асар, майхан, гэр худалдан авахад 21,960.0 мянган төгрөг/ зарцуулсан,*
- Мөн Засаг даргын нөөц сангаас Бугант тосгоны ЕБС-д 2-р хоолны тогоо худалдан авахад 4,300.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.
- **Засаг даргын Тамгын газар:**Суваг Ти Ви найм “ телевизтэй гэрээ айгуулж, сумын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах зорилгоор нэвтрүүлэг бэлтгэхэд “4,000.0 мянган төгрөг шилжүүлсэн,
- 2017-2021 онд үүссэн АТӨЯХАТ болон зам ашигласны төлбөр 422.2 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөг үүсгэлгүйгээр тайлант оны зардлаас санхүүжүүлж, бүртгэсэн,
- Өмч хамгаалах зөвлөлөөр эвдрэл, гэмтлийг тогтоогоогүй буюу техникийн комиссын акт, дүгнэлтгүйгээр автомашины засвар үйлчилгээнд 2,250.0 мянган төгрөг зарцуулсан.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

- Нутгийн өөрөө удирдах байгууллагыг иргэдэд сурталчлах зорилготой сургалт зохион байгуулахад 5,000.0 мянган төгрөгийн дэвтэр, бал авч төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан,
- Сургалт явагдсаныг батлах гүйцэтгэлийн тайлангүйгээр “Сургалт судалгааны полиси төв”-тэй хамтран сургалт зохион байгуулахад 5,000.0 мянган төгрөг,

төлөөлөгчдийн чадавхжуулах зорилгоор “Хувь хүний хөгжлийн алсын хараа” ТББ-тай хамтран сургалт зохион байгуулахад 10,000.0 мянган төгрөг зарцуулсан,

- Өмч хамгаалах зөвлөлөөр эвдрэл, гэмтлийг тогтоогоогүй буюу техникийн комиссын акт, дүгнэлтгүйгээр автомашины засвар үйлчилгээнд 2,000.0 мянган төгрөг зарцуулсан,
- Төлөөлөгчдийн хуралдааны хоолны зардлыг гүйцэтгэлээр бус төлөвлөсөн дүнгээр Мянган цагаан туг, Ашид тогтуун зэрэг компаниудад шилжүүлж, бүртгэл тайланд тусгасан.

Бугант тосгоны Захирагчийн алба:

- 2010 онд иргэн Д.Рэгээдээс орон нутгийн өмчид шилжүүлсэн орон сууцыг тосгоны Захирагчийн захирамжаар ЭМТ-д худалдан борлуулсны орлого 33,000.0 мянган төгрөгийг нярав М.Туянагийн хувийн харилцах дансаар дамжуулан бэлнээр орлого авч, төрийн сангийн дансанд тушаалгүй, зарцуулалтын эрх үүсгэлгүйгээр зарцуулсан,
- Бугант тосгоны Захирагчийн захирамжаар “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнагдсан болон өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн 3 төрийн албан хаагчид нийт 500.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал болон буцалтгүй тусламж олгосон,
- 2021 онд зам засварын ажил гүйцэтгэхэд үүссэн 4,969.4 мянган төгрөгийн шатахууны өглөгийг санхүүгийн тайланд тусгалгүйгээр тайлант оны төсвөөс санхүүжүүлсэн,
- Өмч хамгаалах зөвлөлөөр эвдрэл, гэмтлийг тогтоогоогүй буюу техникийн комиссын акт, дүгнэлтгүйгээр автомашины засвар үйлчилгээнд 2,681.0 мянган төгрөг зарцуулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Ерөө сумын ИТХ-ын “2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 2022 оны 55 дугаар тогтоолоор 4,375,912.8 мянган төгрөгийн татварын орлого, 110,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 6,167,412.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 137.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------------------------------|--------------|--------------|--------------|--------|
| Татварын орлого | 4,375,912.80 | 5,885,985.90 | 1,510,073.10 | 134.51 |
| Хүн амын орлогын албан татвар | 3,073,000.00 | 2,298,478.20 | (774,521.80) | 74.80 |
| Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого | 3,000,000.00 | 2,198,203.90 | (801,796.10) | 73.27 |

| | | | | |
|---|---------------------|---------------------|---------------------|---------------|
| Үйл ажиллагааны орлого | 13,000.00 | 27,335.20 | 14,335.20 | 210.27 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 10,000.00 | 29,070.30 | 19,070.30 | 290.70 |
| Хөрөнгийн орлого/ Хадгаламжийн хүүгийн татварын орлого/ | 50,000.00 | 43,868.80 | (6,131.20) | 87.74 |
| Хөрөнгийн албан татвар | 188,500.00 | 156,820.60 | (31,679.40) | 83.19 |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 35,000.00 | 12,640.30 | (22,359.70) | 36.12 |
| Бууны албан татвар | 3,500.00 | 4,422.00 | 922.00 | 126.34 |
| Малд ноогдуулах албан татвар | 150,000.00 | 139,758.30 | (10,241.70) | 93.17 |
| Барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн бусад татвар | 62,000.00 | 121,642.90 | 59,642.90 | 196.20 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 27,000.00 | 99,232.30 | 72,232.30 | 367.53 |
| Хог хаягдлын хураамжийн орлого | 25,000.00 | 14,383.40 | (10,616.60) | 57.53 |
| ТТАМАТөлбөр | 10,000.00 | 8,027.20 | (1,972.80) | 80.27 |
| Газрын төлбөр | 476,463.30 | 457,088.20 | (19,375.10) | 95.93 |
| Газрын төлбөр | 275,435.30 | 303,443.40 | 28,008.10 | 110.17 |
| Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт | 201,028.00 | 153,644.80 | (47,383.20) | 76.43 |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр | 575,949.50 | 2,851,956.00 | 2,276,006.50 | 495.17 |
| Ойн нөөц ашигласны төлбөр | 564,971.50 | 2,841,242.50 | 2,276,271.00 | 502.90 |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 3,178.00 | 1,903.00 | (1,275.00) | 59.88 |
| Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр | 7,800.00 | 8,810.50 | 1,010.50 | 112.96 |
| Татварын бус бусад орлого | 110,000.00 | 281,426.70 | 171,426.70 | 255.84 |
| Нэр заагдаагүй бусад орлого | 10,000.00 | 195,178.50 | 185,178.50 | 1,951.79 |
| Хүү, торгуулийн орлого | 100,000.00 | 86,248.20 | (13,751.80) | 86.25 |
| НИЙТ ДҮН | 4,485,912.80 | 6,167,412.60 | 1,681,499.80 | 137.48 |

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд үйл ажиллагааны орлого 14,335.2 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 19,070.3 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 72,232.3 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 28,008.1 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 2,841,242.5 мянган төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлого 185,178.5 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Орлогын гүйцэтгэлээр цалин хөлс түүнтэй адилтгах хөрөнгийн орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, малд ноогдуулах албан татвар, газрын дуудлага худалдааны орлого, хүү, торгуулийн орлого, хог хаягдлын хураамж зэрэг орлогууд тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- ✓ **Үйл ажиллагааны орлого:** ХХААХҮЯ-аас 2020, 2021 оны улаан буудай болон ноосны урамшуулал олгосонтой холбоотой,
- ✓ **Улсын тэмдэгтийн хураамж болон ойн нөөц ашигласны төлбөр:** Сумын ИТХ-ын тогтоолоор 5 дугаар сард орлогын төлөвлөгөөг бууруулсан боловч 8 дугаар сард БОЯ, Ойн судалгаа хөгжлийн төв, Ойн ангитай хамтран самрын нөөц тогтоох ажлыг зохион байгуулснаар 25 ААН-тэй гэрээ байгуулж, тэмдэгтийн хураамж болон ойн нөөц ашигласны орлого нэмэгдсэн,

- ✓ **Нэр заагдаагүй бусад орлого:** Самрын нөөц тогтоох ажлыг зохион байгуулснаар Ойн ангийн талбай тусгаарлалтын орлого өссөн байна.

Тасарсан орлогууд:

- ✓ **Цалин хөлс, түүнтэй адилтгах хөрөнгийн орлого:** Хамгийн том татвар төлөгч Болд төмөр Ерөө гол ХХК нь 8 дугаар сараас хойш татвараа дутуу төлсөнтэй холбоотой,
- ✓ **Газрын дуудлага худалдааны орлого:** Олон удаагийн газрын дуудлага худалдаанд оролцогч оролцоогүйтэй холбоотой,
- ✓ **Үл хөдлөх хөрөнгийн албан татвар, малд ноогдуулах албан татвар, хог хаягдлын хураамж:** Татварын байцаагч, хог хаягдлын байцаагч, багийн дарга нартай хамтран ажиллаж, айл өрхүүдээр явж мэдэгдэл өгсөн боловч дутуу төвлөрсөн,
- ✓ **Хүү, торгуулийн орлого:** Орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөснөөс тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 6,235,804.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 41 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 5,135,912.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 41,885.0 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 1,480,400.0 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 47,817.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 771,730.3 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 100,000.0 мянган төгрөг, нийт 7,577,745.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 55 дугаар тогтоолоор аймгийн 2022 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 55 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 650,000.0 мянган төгрөгөөр бууруулан 4,485,912.8 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 41,885.0 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс 1,480,400.0 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 47,817.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 771,730.3 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 100,000.0 мянган төгрөг зэрэг нийт **6,927,745.1** мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, **5,529,267.2** мянган төгрөгийг зарцуулан, **1,398,477.9** мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 6,167,412.6 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 771,730.3 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 279,259.2 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 87,933.6 мянган төгрөг

зэрэг нийт **7,306,335.7** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн, **1,398,477.9** мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **4,791,946.5** мянган төгрөг буюу 86.7 хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 53,906.3 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардал 4,156.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 38,133.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 2,153.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 3,963.8 мянган төгрөгөөр, томилолтын зардал 1,087.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 21,613.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 40,332.9 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 683.6 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 472,289.4 мянган төгрөгөөр, эргэн төлөгдөх зээл 99,000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 19 төсөл, арга хэмжээнд 1,500,643.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 1,255,404.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 245,238.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 3 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 20 төсөл, арга хэмжээнд 919,547.3 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 692,496.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 227,050.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч урьдчилгаа санхүүжилт аваад ажлаа эхлүүлээгүй тул шалгуулахаар хууль, хяналтын байгууллагад холбогдох материалыг хүргүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 250,850.2 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 20,648.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 77,953.1 мянган төгрөг зэрэг нийт **349,451.4** мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин, НДШ-ийн зардалд 8,295.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 3,500.6 мянган төгрөг, нормативт зардалд 18,312.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 3,251.8 мянган төгрөг, томилолтын зардалд 180.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр СЭА-2023/04-НА-СТА-ТТЗ

хураамжийн зардалд 1,290.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 145,614.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 5,953.4 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 189,841.0 мянган төгрөг зэрэг нийт **376,059.4** мянган төгрөгийн зардал гаргаж, өмнөх оны үлдэгдлээс **26,608.0** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ерөө сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн автомашины засварын зардлыг гаргах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөх, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг улирал бүр үнэлж, урамшуулал олгож байх, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг иж бүрэн хийж зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөө сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 88 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 6,561,795.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 65,617.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан ЕБС-ууд, цэцэрлэгүүд, ЭМТ-үүд зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан тус тусын яаманд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 5,173,437.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **51,734.4** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэлийг хүргүүлсэн байна.

Үүнээс Ерөө сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- *Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын батлагдсан төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар жилийн эцэст батлагдсан төсвийг 13.3 хувиар хэмнэсэн,*
- *Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтуудыг зөрчсөн нийт 48,838.8 мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Сумын ИТХ нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах зорилготой сургалт зохион байгуулахад 5,000.0 мянган төгрөгийн дэвтэр, бал авч төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан,
- Сургалт зохион байгуулсныг нотлох гүйцэтгэлийн тайлангүйгээр “Сургалт судалгааны полиси төв”-тэй хамтран сургалт зохион байгуулахад 5,000.0 мянган төгрөг, төлөөлөгчдийг чадавхжуулах зорилгоор “Хувь хүний хөгжлийн алсын хараа” ТББ-тай хамтран сургалт зохион байгуулахад 10,000.0 мянган төгрөг зарцуулсан,
- ЗДТГ нь сумын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах зорилгоор нэвтрүүлэг бэлтгэхэд “Суваг Ти Ви найм” телевизтэй гэрээ байгуулж 4,000.0 мянган төгрөг шилжүүлсэн,

- Сумын Засаг даргын 2022 оны А/273 дугаар захирамжаар улсын төсөвт байгууллагуудын 7 албан хаагчдад 700.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг ЗДНХ-өөс олгосон,
- Бугант тосгоны захирагчийн захирамжаар “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнагдсан болон ажлаас чөлөөлөгдсөн 3 төрийн албан хаагчид нийт 500.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал, буцалтгүй тусламж олгосон,
- Тендерийн хэмнэлтээр сумын ОНХО-аар хэрэгжсэн 289,098.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгоны орон сууцуудын подвалын цэвэр, дулааны шугам шинэчлэх” ажилд 8,506.6 мянган төгрөгийн, ОНХС-аар хэрэгжсэн 274,786.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгоны 2 км хайрган хучилттай зам барих” ажилд 15,132.2 мянган төгрөгийн нэмэлт гэрээ тус тус байгуулсан байна.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.2 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3: “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

| д/д | Байгууллагын нэр | Мэдээлбэл зохих | Мэдээлсэн | Хугацаа хоцроосон | Мэдээлээгүй |
|-----|---------------------------------|-----------------|-----------|-------------------|-------------|
| 1 | Төсвийн төвлөрүүлэн захирагч | 155 | 143 | 12 | - |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 151 | 150 | 1 | - |
| 3 | Засаг даргын Тамгын газар | 151 | 150 | 1 | - |
| 4 | Бугант тосгоны Захирагчийн алба | 151 | 110 | 41 | - |

| | | | | | |
|---|----------------------|------------|------------|------------|----------|
| 5 | Ерөө бүсийн Ойн анги | 151 | 106 | 45 | - |
| | Нийт дүн | 759 | 659 | 100 | - |

ТТЗ-ийн дүнгээр нийт мэдээлбэл зохих 759 мэдээллээс 659 мэдээллийг хугацаанд нь, 100 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн актыг бүрэн биелүүлж, 193,172.9 мянган төгрөгийн албан шаардлага, 65,929.0 мянган төгрөгийн 6 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг аудитаар дахин хянахад 55.7 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар | | Биелэлт | | |
|-----------------|----------------|------------------|-----------|------------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 341.7 | 1 | 341.7 | |
| Албан шаардлага | 3 | 196,265.3 | 3 | 193,172.9 | 98.4 |
| Зөвлөмж | 7 | 268,253.8 | 6 | 65,929.0 | 24.5 |
| Нийт дүн | 11 | 464,860.8 | 10 | 259,101.9 | 55.7 |

Өмнөх аудитаар өгсөн бараа материалын худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх гэсэн зөвлөмжийг орон нутгийн байгууллагууд нь хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Өмнөх аудитаар авлага үүсгэхгүй ажиллах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах гэсэн албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар

зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн холбогдох албан тушаалтнуудад **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг шалгаж амжаагүй тул Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

Тус сумын батлагдсан төсөвтэй холбоотой дараах асуудлуудыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Сумын ИТХ-ын төсөвт үндсэн чиг үүрэгт хамааралгүй Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 21,545.6 мянган төгрөгийн төсөв баталсан байгаа нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3¹, 46.6² дахь заалт болон Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 1.5³, 2.7⁴ дахь заалтуудтай нийцэхгүй байна. Сумын ИТХ нь дээрх асуудалтай холбоотой бодлогыг тодорхойлж, тухайн арга хэмжээний зарцуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй байгууллага юм. Иймд цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг холбогдох төсөвт нь тусгаж, батлах шаардлагатай.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл болон Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргад орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх судалгааг гаргаж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу татан төвлөрүүлж, орон нутгийн байгууллагын нийтлэг үйлчилгээний хүрээнд дуудлагын

¹ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Салбар зөвлөл, гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын төлөвийг харгалзан хуваарилж, зарцуулна.

² Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгийг зөрчлийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлыг харгалзан асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тухай бүр тусгаж, зарцуулна.

³ Батлагдсан хуваарийн дагуу аймаг, нийслэлийн төсвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан сум, дүүргийн төсөвт олгосон хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн нэрээр тусгай дансанд төвлөрүүлнэ.

⁴ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар дараах зориулалтаар зарцуулна.

автомашины зориулалтаар ашиглуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг даалгасан байна. Гэвч өнөөдрийг хүртэл дээрх тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс тус ИТХ-ын ажлын алба өөрийн байгууллагад бүртгэлтэй Ланд крузер 100, приус 40 автомашиныг албан хэрэгцээнд ашиглаж шатахуунд 8,964.3 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэлд 2,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Энэ төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулагдах эрсдэлийг үүсгэж байгаа тул уг асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

- Тайлант онд ИТХ-ын дарга ИТХ-ын төсвийг захиран зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д *"Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна: 16.4.14."... сум, ... иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн;* " гэсэн заалттай нийцэхгүй байна. Цаашид ИТХ-ын нарийн бичгийн даргын сул орон тоог нэн даруй нөхөж, төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгүүлэх нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 90,905.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа⁵ илэрч алдааг цаашид арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв. Үүнд:

ЗДТГ :

- Сумын хөрөнгө оруулалтын зардлаар санхүүжүүлсэн 97,526.0 мянган төгрөгийн гэрээтэй "Засаг даргын Тамгын газрын байрны зураг төсөв"-ийн ажлын урьдчилгаа **78,020.8 мянган** төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй, санхүүгийн тайланд үнэн зөв, бодитоор тайлагнаагүй,
- Тайлант онд худалдан авсан 4,180.3 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, хүнсний материал, барилгын засварын материалыг бүртгэхдээ ангиллын дагуу бус бусад хангамжийн материалд бүртгэн тайлагнасан.

Ойн анги:

- 7,777.2 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдлийг нэр, төрлөөр тухай бүрд нь бус бөөн дүнгээр бүртгэсэн,

Бугант тосгоны Захирагчийн алба:

- Тайлант онд худалдан авсан 927.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардлаар тайлагнасан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, 13.4 -д *"Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь *"Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан*

⁵ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.5.(б) “Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн зарлага нь бараа материал худалдан авсан болон бусад байгууллага, хүмүүсээс авсан үйлчилгээний төлбөр байна. Дт. Урьдчилгаа (урьдчилж төлсөн зардал гэх мэт) , Кт. Мөнгөн хөрөнгө “, 4.21-д “Бараа материалыг (хангамжийн зүйлийг) худалдан авсан үед: Дт. Хангамжийн материал, Кт. Мөнгөн хөрөнгө / Дансны өглөг”, 4.8-д “Жилийн батлагдсан төсөвт тусгагдсаны дагуу гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр хийгдэж байгаа урт хугацаат хөрөнгө оруулалтын ажлын урьдчилж төлсөн зардлыг дээрхийн адилаар бүртгэнэ.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Дээрх алдаануудыг 2023 оны эхний хагас жилд багтаан санхүүгийн тайланд залруулах, бараа материалын хөдлөл өөрчлөлтийг холбогдох стандарт, заавар, журмын дагуу үнэн зөв бүртгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 331,114.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,398.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 318,785.7 мянган төгрөгийн 7 зөрчилд албан шаардлага, 6,931.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

5.1.1 Холбогдох байгууллагын хүсэлтгүйгээр ЗДТГ болон улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардлаас байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 70,000.0 мянган төгрөгийн зохицуулалт хийж /Хяналтын 4 пост ажиллах, цагдаагийн албан хаагчдын томилолт, шатахууны зардал/, улсын төсөвт байгууллага болох аймгийн Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн боловч зарцуулалтыг нотлох анхан шатны гүйцэтгэлийн баримт материалыг бүрдүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” , Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.2.1-д “Төсөвт зохицуулалт хийхийг хүссэн албан бичиг” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийж, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2.2 2010 онд иргэн Д.Рэгзэдээс орон нутгийн өмчид шилжүүлсэн орон сууцыг тосгоны захирагчийн захирамжаар ЭМТ-д худалдан борлуулсны орлого 33,000.0 мянган төгрөгийг нярав М.Туянагийн хувийн харилцах дансаар дамжуулан бэлнээр орлого авч, төрийн сангийн дансанд тушаалгүй, зарцуулалтын эрх үүсгэлгүйгээр дараах зардлуудад зарцуулсан байна. Үүнд:

- Биеийн тамирын хувцас авахад 5,491.0 мянган төгрөг /шүгэл,ракет-93.0 мянган төгрөг/,
- Лед урсдаг самбар авахад 5,900.0 мянган төгрөг,
- Зарсан орон сууцны засварт 8,000.0 мянган төгрөг,
- Албан өрөөний хөшиг худалдан авахад 1,790.8 мянган төгрөг,
- Автогрейдер, машины засварт 7,177.8 мянган төгрөг,
- Бусад автомашины засварт 4,700.4 мянган төгрөг гэх мэт.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь “Төсвийн байгууллага төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна.”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6 дахь “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-аас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй /ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.”, 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 1.4 дэх “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын зарцуулалт, тайлагналтыг Төрийн сангаар дамжуулан гүйцэтгэнэ.”, 4.3 дахь “Энэ журмын 3.1.2-т заасан төсвийн жилийн дундуур шинээр бий болсон нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж ... хүлээн авч хянасны үндсэн дээр тухай бүр нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээж санхүүжүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн тосгоны захирагч Д.Эрдэнэбулганд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх, биеийн тамирын хувцасны 5,398.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нийт 48,838.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “ Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.2 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3: “сургалт, семинар, хурал, СЭА-2023/04-НА-СТА-ТТЗ

зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

1. Сумын ИТХ нь нутгийн өөрөө удирдах байгууллагыг иргэдэд сурталчлах зорилготой сургалт зохион байгуулахад 5,000.0 мянган төгрөгийн дэвтэр, бал авч төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан,
2. Сумын ИТХ нь гүйцэтгэлийн тайлангүйгээр “Сургалт судалгааны полиси төв”-тэй хамтран сургалт зохион байгуулахад 5,000.0 мянган төгрөг, төлөөлөгчдийн чадавхжуулах зорилгоор “Хувь хүний хөгжлийн алсын хараа” ТББ-тай хамтран сургалт зохион байгуулахад 10,000.0 мянган төгрөг зарцуулсан,
3. ЗДТГ нь сумын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах нэвтрүүлэг бэлтгэхэд “Суваг Ти Ви найм “ телевизтэй гэрээ байгуулж 4,000.0 мянган төгрөг шилжүүлсэн,
4. Сумын Засаг даргын 2022 оны А/273 дугаар захирамжаар улсын төсөвт байгууллагын 7 албан хаагчдад 700.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг ЗДНХ-өөс олгосон,
5. Бугант тосгоны захирагчийн захирамжаар “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнагдсан болон ажлаас чөлөөлөгдсөн 3 төрийн албан хаагчид нийт 500.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал, буцалтгүй тусламж олгосон,
6. Тендерийн хэмнэлтээр сумын ОНХО-аар хэрэгжсэн 289,098.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгоны орон сууцуудын подвалын цэвэр, дулааны шугам шинэчлэх” ажилд 8,506.6 мянган төгрөгийн, ОНХС-аар хэрэгжсэн 274,786.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгоны 2 км хайрган хучилттай зам барих” ажилд 15,132.2 мянган төгрөгийн нэмэлт гэрээ тус тус байгуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2.4 Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс гамшгаас хамгаалах болон хөрөнгө худалдан авах зардлыг санхүүжүүлж, зориулалт бусаар 28,114.6 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь “Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө **1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж,төлөвлөж зарцуулна.**”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь “энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ”, 3.1.2 дахь “... энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Засаг даргын захирамжаар “Гамшгийн иж бүрэн сургалт” зохион байгуулахад 23,814.6 мянган төгрөг /*Үүнээс асар, майхан, гэр зэрэг хөрөнгө худалдан авахад 21,960.0 мянган төгрөг*/,
- Бугант тосгоны ЕБС-д 2-р хоолны тогоо худалдан авахад 4,300.0 мянган төгрөг.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг холбогдох төсөвт тусган төлөвлөж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2.5 Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй нийт **131,954.7 мянган төгрөгийн** /ЗДТГ нь 41,979.5 мянган төгрөг, Ойн анги нь 39,974.7 мянган төгрөг, Захирагчийн алба нь 35,027.8 мянган төгрөг, ИТХ нь 14,972.7 мянган төгрөг, /бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй болон бөөн дүнгээр баталгаажуулсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

5.2.6 Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс нийт 1,486.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Сумын ЗДТГ нь ХХОАТ-ын 967.1 мянган төгрөгийн авлага үүсгэж дутуу тайлагнасан,
- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Бугант тосгоны 2 км хайрган хучилттай зам барих ажил”-ын гүйцэтгэгч Сэлэнгэ 9 эрдэнэ ХХК-д 518.9 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү олгож авлага үүсгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах, төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2.7 Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр 5,391.6 мянган төгрөгийг өр төлбөрийг тайлант оны төсвөөс шилжүүлсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.3-д “*бүх өр төлбөр*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Үүнд:

- Буган тосгоны Захирагчийн алба нь 2021 онд зам засварын ажил гүйцэтгэхэд үүссэн 4,969.4 мянган төгрөгийн шатахууны өглөг,
- Сумын ЗДТГ нь 2017-2021 онд үүссэн АТӨЯХАТ болон зам ашигласны төлбөр 422.2 мянган төгрөг.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй байх, үүссэн өр төлбөрийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Өмч хамгаалах зөвлөлөөр эвдрэл, гэмтлийг тогтоогоогүй буюу техникийн комиссын акт, дүгнэлтгүйгээр автомашины засвар үйлчилгээнд дараах байгууллагууд нийт 6,931.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- ЗДТГ нь 2,250.0 мянган төгрөг,
- ИТХ нь 2,000.0 мянган төгрөг,
- Бугант тосгоны Захирагчийн алба 2,681.0 мянган төгрөг.

1.2 Өгсөн зөвлөмж: Техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн автомашины засварын зардлыг гаргаж байх.

2.1 Илрүүлэлт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулагдах зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ын хавсралтад заасан зардлын ангилал нэр төрлөөр бус бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардалд бөөнөөр нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг бүлэг, зүйлээр төлөвлөж, хянах зарчмыг алдагдуулж байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж байх.

3.1 Илрүүлэлт: ЗДТГ, ИТХ, Захирагчийн алба, Ойн анги зэрэг байгууллагууд нь төрийн албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр үнэлж, үр дүнгийн урамшуулал олголгүйгээр хагас, бүтэн жилээр дүгнэн, урамшууллыг дутуу олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.3-д *“Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үнэлэн улирал бүр үр дүнгийн мөнгөн урамшуулал олгож байх.

4.1 Илрүүлэлт: ИТХ нь төлөөлөгчдийн хуралдааны хоолны зардлыг гүйцэтгэлээр бус төлөвлөсөн дүнгээр Мянган цагаан туг, Ашид тогтуун зэрэг компаниудад шилжүүлж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 13.7 дэх *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Төлөөлөгчдийн хуралдааны хоолны зардлыг гүйцэтгэлээр тооцож, шилжүүлж байх.

2 Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

2.1.1 Илрүүлэлт: Орон нутгийн байгууллагууд нь санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь *“Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”*, 8.1.5 дахь *“санхүүгийн тайлангийн тодруулга”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.1.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|------------------|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----------------|------------|-----|--------------|-----------------|----------|-----------------|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 2 | 82,201.1 | | | 2 | 82,201.1 | | | 2 | 82,201.1 | 2 | 82,201.1 |
| Захирагчийн алба | 1 | 927.0 | | | 1 | 927.0 | | | 1 | 927.0 | 1 | 927.0 |
| Ойн анги | 1 | 7,777.2 | | | 1 | 7,777.2 | | | 1 | 7,777.2 | 1 | 7,777.2 |
| Дүн | 4 | 90,905.3 | | | 4 | 90,905.3 | | | 4 | 90,905.3 | 4 | 90,905.3 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|------------------|-------------|------------------|---------------|----------------|-----------------|------------------|----------|----------------|--------------------------------------|----------|---|-----|
| | | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТТЗ | 2 | 122,453.4 | | | 1 | 122,453.4 | | | 1 | | | |
| ЗДТГ | 3 | 50,137.7 | | | 1 | 47,887.7 | 2 | 2,250.0 | | 1 | | |
| ИТХ | 3 | 36,972.7 | | | 1 | 34,972.7 | 2 | 2,000.0 | | | | |
| Захирагчийн алба | 3 | 81,576.2 | 1 | 5,398.0 | 1 | 73,497.2 | 1 | 2,681.0 | | 2 | | |
| Ойн анги | 1 | 39,974.7 | | | 1 | 39,974.7 | | | | 1 | | |
| Дүн | 12 | 331,114.7 | 1 | 5,398.0 | 5 | 318,785.7 | 5 | 6,931.0 | 1 | 4 | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|-----------|-----|
| | | | | | | | Тоо | Дүн |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| ТТЗ шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон | 12 | | | | | | 12 | |
| Захирагчийн алба шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон | 41 | | | | | | 41 | |
| ЗДТГ шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон | 45 | | | | | | 45 | |
| Дүн | 98 | | | | | | 98 | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 98 | | | | | | 98 | |